



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.6, Монгол улсын засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 5.4 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь :

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”, “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”- ийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үнэлгээний дүнг 2015 оны 4 дүгээр улиралд удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ХШҮДАГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Оюунсүрэнд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081113

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08 сарын 19 өдрийн  
3/9 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Э.Оюунсүрэн, ХШУДАГ-ын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Р.Байгалмаа, Хяналт-шинжилгээ  
үнэлгээ, дотоод аудитын газрын  
мэргэжилтэн

Гишүүд:

А.Өнөржаргал, Эрүүл мэндийн  
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах  
газрын мэргэжилтэн

Н.Оюунгэрэл, Стратеги, бодлого  
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

М.Насанбаян Стратеги, бодлого  
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Г.Өлзийбуян, Хяналт-шинжилгээ  
үнэлгээ, дотоод аудитын газрын  
мэргэжилтэн

Л.Мөнхцэцэг, Стратеги бодлого  
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

С.Солонго, Эрүүл мэндийн хөгжлийн  
төвийн албаны дарга

Ч.Зулцэцэг, Эрүүл мэндийн  
хөгжлийн төвийн албаны дарга

Д.Уранчимэг, Эрүүл мэндийн  
хөгжлийн төвийн албаны дарга

Ч.Өнөрсайхан, Монголын өрхийн  
анагаах ухааны мэргэжилтнүүдийн  
Холбооны гүйцэтгэх захирал  
/Зөвшилцсөнөөр/

Ц.Ганхүү, Сумын эмч нарын  
холбооны гүйцэтгэх захирал  
/Зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08 сарын 19 өдрийн  
319 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

**“СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ”, ӨРХИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ.**

**Үндэслэл:**

“Эрүүл мэндийн салбарын анхан шатны тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратеги” батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2013 оны 239, 386 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангах

**Зорилго:**

“Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж дэвшүүлэх.

**Үйл ажиллагааны чиглэл:**

“Эрүүл мэндийн салбарын анхан шатны тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги” ийн явцын үнэлгээг дараах чиглэлээр гүйцэтгэнэ.

Сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хүрээнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 239 дугаар тушаалаар батлагдсан “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ;
2. “Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2013.07.09 ний 246 дугаар тушаалын хэрэгжилтэд үнэлгээ өгөх
3. “Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум, дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” Монгол улсын стандарт MNS: 5081:2013 –ын хангалтын байдалд үнэлгээ өгөх
4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй эмнэлзүйн заавруудын хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүрээнд :

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх
2. “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2013.07.09 248 дугаар тушаал
3. “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” Монгол улсын стандарт MNS: 5292:2011-ын хангалтын байдалд үнэлгээ өгөх

4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй эмнэлзүйн заавруудын хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх

Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох эрх зүйн шийдвэрүүд, үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтүүд, хамтран ажилласан олон улсын болон орон нутгийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны байдалд тус тус дүн шинжилгээ хийх,

Холбогдох бусад материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгнө.

**Хамрах хүрээ:**

- Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргаа удирдлагын газар, Стратеги бодлого төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, сонгогдсон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өрх, сумын эрүүл мэндийн төвийн үнэлгээ өгөгдсөн материалуудыг ашиглах

**Зохион байгуулагч:**

Эрүүл мэнд спортын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Стратеги бодлого төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар.

**Хугацаа:**

2015 оны 9,10,11 дүгээр сар

**Санхүүжилт:** ДЭМБ 1500 ам доллар

**Хүрэх үр дүн:** “Эрүүл мэндийн салбарын анхан шатны тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийгдэж, дүнг Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.